



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101

Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2024.02.23. № 1/231
танай _____ -ны № _____ -т

Г БАЯНХОНГОР СУМЫН ЕРӨНХИЙ Г
БОЛОВСРОЛЫН СООГО СЕЙКЕО
СУРГУУЛИЙН ТӨСВИЙН ЗАХИРАГЧ
Д.ЦЭДЭНСОДНОМ ТАНАА

Баянхонгор сумын ерөнхий боловсролын
Соого Сейкео сургуулийн 2023 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан, дүгнэлтийг
хүргүүлж байна.

Хавсралт хуудастай

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б. МӨНХБАТ

5030448



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор сумын Соого Сейкео сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2024/97/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Баянхонгор хот

2024 оны 02 дугаар сар 20

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын
Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Ахлах аудитор М.Алтантуяа
Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Номгон аудит ХХК
Захирал Г.Саранчимэг
Утас: 89891034 Цахим хаяг: audit.nomgon@gmail.com
Аудитор: О.Мандах
Утас: 89010203 Цахим хаяг: audit.nomgon@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	15
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг





**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

2024.02.23 № 2/31
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын ерөнхий боловсролын Соого Сейкео сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор сумын ерөнхий боловсролын Соого Сейкео сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 2023 онд 71802 хөтөлбөрийн 11 арга хэмжээний зардалд 1,873,234.1 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 1,601,155.0 мянган төгрөгийг зарцуулж, төсөвт 2,184.6 мянган төгрөгийг төвлөрүүлж, оны эцэст харилцах дансанд 271,140.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Аудитын гол асуудал

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

5020142

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээх бөгөөд Баянхонгор сумын Соого Сейкео сургуулийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын 42 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 94.5 хувьтай тайлагнасныг дээд шатны байгууллагаас 86.3 хувиар үнэлсэн байна.

Баянхонгор сумын Соого Сейкео сургуулийн 2023 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй, аудитад ажил гүйлгээг түүврийн аргыг ашиглан гүйцэтгэсэн болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төгрөгөөр	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	261,355,228.11	337,347,160.11
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	201,488,514.00	271,140,571.00
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	201,488,514.00	271,140,571.00
31210	Төгрөг	201,488,514.00	271,140,571.00
31211	Төрийн сангийн харилцах	201,488,514.00	271,140,571.00
35	БАРАА МАТЕРИАЛ	59,866,714.11	66,206,589.11
35100	Түүхий эд материал	3,230,810.00	2,099,000.00
35130	Эм боох материал	3,230,810.00	2,099,000.00
35400	Хангамжийн материал	56,635,904.11	64,107,589.11
35410	Бичиг хэргийн материал	10,672,285.00	15,444,301.00
35420	Аж ахуйн материал	43,789,319.11	46,626,988.11
35450	Барилгын засварын материал	2,174,300.00	2,036,300.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,418,309,301.93	1,380,836,147.43
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,418,309,301.93	1,380,836,147.43
39200	Биет хөрөнгө	1,209,834,301.93	1,172,361,147.43
39201	Барилга, байгууламж, орон сууц	966,092,361.00	966,092,361.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-95,270,076.45	-124,118,931.33
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	347,884,445.12	306,976,095.12
39206	Хуримтлагдсан элэгдэл	-117,665,763.31	-110,035,901.15
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	86,713,011.04	113,090,211.04
39208	Хуримтлагдсан элэгдэл	-45,722,260.66	-45,253,627.48
39214	Бусад үндсэн хөрөнгө	37,041,500.00	37,041,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-12,822,387.84	-16,027,984.80
39217	Ном	43,583,473.03	44,597,425.03
39300	Биет бус хөрөнгө	208,475,000.00	208,475,000.00
39301	Программ хангамж	770,000.00	770,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-770,000.00	-770,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	208,475,000.00	208,475,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,679,664,530.04	1,718,183,307.54
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,679,664,530.04	1,718,183,307.54
51	Засгийн газрын хувь оролцоо	1,679,664,530.04	1,718,183,307.54
51100	Засгийн газрын оруулсан капитал	462,571,101.29	462,571,101.29
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	462,571,101.29	462,571,101.29
51200	Хуримтлагдсан үр дүн	726,827,447.02	765,346,224.52
51210	Өмнөх үеийн үр дүн	-952,837,083.02	726,827,447.02
51220	Тайлант үеийн үр дүн	1,679,664,530.04	38,518,777.50
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	490,265,981.73	490,265,981.73
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,679,664,530.04	1,718,183,307.54

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,655,338,564.90	1,696,461,033.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	149,258,798.90	31,515,533.00
120	Нийтлэг татварын бус орлого	149,258,798.90	31,515,533.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,319,900.00	5,861,600.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,319,900.00	5,861,600.00
120009	Бусад орлого	1,603,900.00	0
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	139,058,998.90	20,871,052.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	7,276,000.00	4,782,881.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,506,079,766.00	1,664,945,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,305,530,900.00	1,526,864,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,305,530,900.00	1,526,864,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	66,485,066.00	0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	134,063,800.00	138,081,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	134,063,800.00	138,081,500.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,314,332,504.52	1,657,942,255.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,314,332,504.52	1,657,942,255.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,158,369,750.52	1,555,818,935.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	825,425,905.00	1,102,510,205.00
210101	Үндсэн цалин	601,349,701.00	743,650,869.00
210102	Нэмэгдэл	186,645,829.00	306,985,474.00
210104	Урамшуулал	19,821,378.00	51,873,862.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	103,029,088.00	138,396,538.00
210201	Тэтгэврийн даатгал	70,949,664.45	95,185,401.71
210202	Тэтгэмжийн даатгал	8,347,021.13	11,206,602.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,633,936.90	8,864,081.67
210204	Ажилгүйдлийн даатгал	1,554,405.96	2,103,065.21
210205	Эрүүл мэндийн даатгал	15,544,059.56	21,037,387.36
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	107,956,990.00	130,896,880.00
210301	Гэрэл, цахилгаан	4,470,025.00	6,255,856.00
210302	Түлш, халаалт	80,805,857.00	101,882,880.00
210303	Цэвэр, бохир ус	22,681,108.00	22,758,144.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,900,720.00	11,274,260.00

**Баянхонгор сумын ерөнхий боловсролын Соого Сейкео сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210401	Бичиг хэрэг	1,291,360.00	2,659,180.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,284,250.00	1,481,720.00
210404	Ном, хэвлэл	0	63,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	784,000.00	725,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,541,110.00	6,344,860.00
2105	Нормативт зардал	1,539,540.00	1,496,810.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,009,040.00	1,301,810.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	530,500.00	195,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,850,000.00	6,656,201.00
210604	Урсгал засвар	4,850,000.00	6,656,201.00
2107	Томилолт, зочны зардал	0	920,000.00
210702	Дотоод албан томилолт	0	920,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,669,800.00	18,016,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,639,800.00	5,861,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0	800,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,030,000.00	11,355,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	80,997,707.52	145,651,441.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,940,000.00	25,356,650.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,221,970.00	15,258,785.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	60,835,737.52	105,036,006.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	155,962,754.00	102,123,320.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	154,516,066.00	99,938,700.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	87,531,000.00	85,041,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	14,897,700.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,446,688.00	2,184,620.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,446,688.00	2,184,620.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	341,006,060.38	38,518,777.50
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	5,586,019.00	0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	335,420,041.38	38,518,777.50

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ӨӨРЧЛӨЛТГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,509,003,566.00	1,670,807,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,923,800.00	5,861,600.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,923,800.00	5,861,600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,319,900.00	5,861,600.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,319,900.00	5,861,600.00
120009	Бусад орлого	1,603,900.00	0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,506,079,766.00	1,664,945,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,305,530,900.00	1,526,864,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,305,530,900.00	1,526,864,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	66,485,066.00	0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	66,485,066.00	0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	134,063,800.00	138,081,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	134,063,800.00	138,081,500.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,247,053,222.00	1,554,463,243.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,247,053,222.00	1,554,463,243.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,092,090,468.00	1,452,339,923.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	825,425,905.00	1,102,510,205.00
210101	Үндсэн цалин	601,349,701.00	743,650,869.00
210102	Нэмэгдэл	186,645,829.00	306,985,474.00
210104	Урамшуулал	19,821,378.00	51,873,862.00
210105	Гэрээт ажлын хөлс	17,608,997.00	0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	103,029,088.00	138,396,538.00
210201	Тэтгэврийн даатгал	70,949,674.98	95,185,401.71
210202	Тэтгэмжийн даатгал	8,347,020.87	11,206,602.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,633,936.92	8,864,081.67
210204	Ажилгүйдлийн даатгал	1,554,405.23	2,103,065.21
210205	Эрүүл мэндийн даатгал	15,544,050.00	21,037,387.36
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	107,956,990.00	130,896,880.00
210301	Гэрэл, цахилгаан	4,470,025.00	6,255,856.00
210302	Түлш, халаалт	80,805,857.00	101,882,880.00

**Баянхонгор сумын ерөнхий боловсролын Соого Сейкео сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210303	Цэвэр, бохир ус	22,681,108.00	22,758,144.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,850,000.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	4,850,000.00	5,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,453,800.00	17,216,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,423,800.00	5,861,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,030,000.00	11,355,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	42,374,685.00	58,319,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,373,970.00	41,130,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,000,715.00	17,189,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	154,962,754.00	102,123,320.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	153,516,066.00	99,938,700.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	87,531,000.00	85,041,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	65,985,066.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0	14,897,700.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,446,688.00	2,184,620.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,446,688.00	2,184,620.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	261,950,344.00	116,343,857.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	60,461,830.00	46,691,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	60,461,830.00	46,691,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	60,461,830.00	46,691,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	60,461,830.00	46,691,800.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-60,461,830.00	-46,691,800.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	201,488,514.00	69,652,057.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	201,488,514.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	201,488,514.00	271,140,571.00

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ӨӨРЧЛӨЛТГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нэээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00
C08	2023 оны 1-р сарын 31-нэээрх үлдэгдэл	462,571,101.29	490,265,981.73	726,827,447.02	1,679,664,530.04
D01	2022 оны 12-р сарын 31-нэээрх үлдэгдэл	462,571,101.29	490,265,981.73	726,827,447.02	1,679,664,530.04
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	462,571,101.29	490,265,981.73	726,827,447.02	1,679,664,530.04
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	38,518,777.50	38,518,777.50
D09	2023 оны 12-р сарын 31-нэээрх үлдэгдэл	462,571,101.29	490,265,981.73	765,346,224.52	1,718,183,307.54

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн үзүүлэлт	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,873,234,100.00	1,601,155,043.00	272,079,057.00	85.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,873,234,100.00	1,598,970,423.00	274,263,677.00	85.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,744,995,300.00	1,499,031,723.00	245,963,577.00	85.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,318,645,900.00	1,102,510,205.00	216,135,695.00	83.6
210101	Үндсэн цалин	872,637,800.00	743,650,869.00	128,986,931.00	85.2
210102	Нэмэгдэл	390,473,400.00	306,985,474.00	83,487,926.00	78.6
210104	Урамшуулал	55,534,700.00	51,873,862.00	3,660,838.00	93.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	164,830,800.00	138,396,538.00	26,434,262.00	84.0
210201	Тэтгэврийн даатгал	112,085,000.00	95,185,401.71	16,899,598.29	84.9
210202	Тэтгэмжийн даатгал	13,186,400.00	11,206,602.05	1,979,797.95	85.0

**Баянхонгор сумын ерөнхий боловсролын Соого Сейкео сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210203	ҮОМШӨ-ний даатгал	10,549,200.00	8,864,081.67	1,685,118.33	84.0
210204	Ажилгүйдлийн даатгал	2,637,300.00	2,103,065.21	534,234.79	79.7
210205	Эрүүл мэндийн даатгал	26,372,900.00	21,037,387.36	5,335,512.64	79.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	133,081.500.00	130,896,880.00	2,184,620.00	98.3
210301	Гэрэл, цахилгаан	6,598,600.00	6,255,856.00	342,744.00	94.8
210302	Түлш, халаалт	101,882,900.00	101,882,880.00	20	100.00
210303	Цэвэр, бохир ус	24,600,000.00	22,758,144.00	1,841,856.00	92.5
2106	Эд хогшил урсгал засварын зардал	5,000,000.00	5,000,000.00		100
210604	Урсгал засвар	5,000,000.00	5,000,000.00		100
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,259,800.00	17,216,600.00	1,043,200.00	94.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,800,000.00	5,861,600.00	938,400.00	86.2
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,459,800.00	11,355,000.00	104,800.00	99.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	105,177,300.00	105,011,500.00	165,800.00	99.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	87,987,600.00	87,821,800.00	165,800.00	99.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,189,700.00	17,189,700.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	128,238,800.00	99,938,700.00	28,300,100.00	77.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	128,238,800.00	99,938,700.00	28,300,100.00	77.9
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	113,341,100.00	85,041,000.00	28,300,100.00	75.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14,897,700.00	14,897,700.00	0.00	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,873,234,100.00	1,668,622,480.00	204,611,620.00	88.3
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,526,864,000.00	1,526,864,000.00	0.00	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,526,864,000.00	1,526,864,000.00	0.00	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	138,081.500.00	135,896,880.00	-2184620	100
132001	Орон нутгийн төсвөөс	138,081.500.00	135,896,880.00	-2184880	100
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	208,288,600.00	5,861,600.00	202,427,000.00	2.8
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,800,000.00	5,861,600.00	938,400.00	86.2
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	201,488,600.00			
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		100
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	68	65		95.5
620001	Удирдах ажилтан	1	1		100
620002	Гүйцэтгэх ажилтан	59	56		95.5
620003	Үйлчлэх ажилтан	8	8		100
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	857	857		100

857 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ӨӨРЧЛӨЛТГҮЙ
САНГАЛ ДҮГИЙЛ 100
005

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор сумын ерөнхий боловсролын Соого Сейкео сургууль нь Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд тодорхойлсон “Суралцагчийг бие даан сурч, амьдрахад шаардагдах суурь мэдлэг, чадварыг хөгжүүлж ёс суртахуунтай, хариуцлагатай, ажил мэргэжлийн чиг баримжаатай иргэнийг төлөвшүүлэхэд оршино” гэсэн зорилтын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг.

Тус сургууль нь Боловсрол, шинжлэх ухааны яамнаас жил бүр дэвшүүлэн тавьсан зорилго зорилтыг хангах үүднээс байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах чиг үүргийн дагуу Сургуулийн захирлын 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дугаар тушаалаар Захиргаа аж ахуй, Сургалтын алба гэсэн бүтэц зохион байгуулалттай 65 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулсан байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг сургуулийн захирал Б.Цэдэнсодном, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Б.Ганбат нар зурж, нярваар С. Болдбаатар ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Бага, дунд боловсролын тухай, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Мэдээллийн ил тод байдлын тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Байгууллагын нууцын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Гамшгаас хамгаалах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Зөрчлийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Архивын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай болон Татварын багц хуулиудыг мөрдөж үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Тайлант онд шинээр Төрийн хэмнэлтийн тухай хуулийг үргэлжлүүлэн мөрдсөн;
- Засгийн газрын 2023 оны 240, 241 дүгээр тогтоолоор албан хаагчдын цалин нэмэгдсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.



3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор сумын ерөнхий боловсролын Соого Сейкео сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй Баянхонгор аймгийн СТСХ-ээс бэлтгэж гаргасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор сумын ерөнхий боловсролын Соого Сейкео сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 38,518,8 мянган төгрөгөөр буюу 2.2 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	201488.5	271140.6	69,652.10
Авлага	0	-	0)
Бараа материал	59866.7	66206.6	6339.9
Үндсэн хөрөнгө	1,690,559.7	1,677,042.5	-13,517.20
Хуримтлагдсан элэгдэл	-272,250.5	-296,206.4	-23955.9
Нийт хөрөнгө	1,679,664.50	1,718,183.30	38,518.80
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,679,664.50	1,718,183.30	38,518.80
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,679,664.50	1,718,183.30	38,518.80

Эх сурвалж: Баянхонгор сумын Соого сейкео сургуулийн санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад Баянхонгор сумын ерөнхий боловсролын Соого Сейкео сургуулийн 2023 оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан дансанд нь мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгийн данс байна.

Мөнгөн хөрөнгийн дансны оны эхний 201,488.5 мянган төгрөг оны эцэст 271,140.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь үдийн цай хөтөлбөр, цалин хөлстэй холбоотой зардлаас хэмнэгдсэнтэй холбоотой үлдэгдэл гарсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 66,206.6 мянган төгрөг болж 6.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Тайлант оны эцэст авлага, өглөггүй ажилласан байна.



Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 02 сарын 13-ний өдрийн 13/08 тоот тогтоолоор 81,080.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталсан.

Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 11 сарын 13-ний өдрийн 107 тоот тогтоолоор 4,035.1 мянган төгрөгийн хүлэмж, Боловсролын ерөнхий газраас 16,835.9 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй орлогоор бүртгэсэн, төсвийн хөрөнгөөр 46,691,9 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч нийт 67,562.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 38,518.8 мянган төгрөгөөр нэмэгдэж, 1,718,183.3 мянган төгрөг болсон байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү данс өөрчлөлтгүй, тайлант үеийн үр дүн 38,518.8 мянган төгрөгөөр нэмэгдэн 1,718,183.3 мянган төгрөг болсон байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,297,996.9 мянган төгрөгөөр төлөвлөж, 2022.07.25-ны өдөр аймгийн СТСХ-т хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн төслөөс 34,352.8 мянган төгрөгөөр буурч 1,263,644.1 мянган төгрөгөөр анх батлагдсан ба төсвийг дээд шатны байгууллагаас 6 удаа тодотгож цалин нэмэгдсэнтэй холбоотой 262,219.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 1,526,864.0 мянган төгрөгөөр баталжээ.

Тайлант онд тус байгууллага төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71802 (Ерөнхий боловсрол) хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс баталсан 1,526,864.0 харилцах дансны үлдэгдлээс 201,488.5 мянга, үйл ажиллагааны орлогоос 6,800.0 мянга нийт 1,735,152.5 төгрөгийн санхүүжилтийг авч, гүйцэтгэлээр 1,465,258.1 мянган төгрөгийг зарцуулж, хэмнэгдсэн 271,140.5 мянган төгрөг харилцах дансанд үлдэгдэлтэй байна.

Орон нутгийн төсвөөс олгохоор баталсан 138,081,5 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, гүйцэтгэлээр батлагдсан санхүүжилтийн 98.4 хувь буюу 135,896.9 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст 2,184.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	80226 Байр ашиглалтын үйлчилгээ	4,583.90	4,583.90	0.00	100
2	80312 Сургалт семинар	4,457.80	4,292.00	165.80	96.3
3	81605 Эрүүл мэндийг дэмжих	5,630.30	5,630.30	0.00	100
4	81801 Үдийн цай хөтөлбөр	113,341.10	85,041.00	28,300.10	75

5	81816 Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	47,878.70	47,878.70	0.00	100
6	81823 Боловсролын байгууллагын багш	10,447.10	10,447.10	0.00	100
7	81834 Боловсролын стандарт, сургалтын	1,425,818.20	1,192,941.10	232,877.10	83.7
8	81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	116,195.50	106,397.80	9,797.70	91.6
9	81848 Сурах бичгийн түрээс	6,800.00	5,861.60	938.40	86.2
10	80112 Нийтлэг үйлчилгээ	138,081.50	135,896.90	2,184.60	98.4
ДҮН		1,873,234.10	1,598,970.40	274,263.70	85.4

Эх сурвалж: Баянхонгор сумын Соого Сейкео сургуулийн төсвийн хэлбэлзэл

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Баянхонгор сумын Соого Сейкео ерөнхий боловсролын сургууль нь тайлант онд үдийн хоол хөтөлбөрт 113,341.1 мянган төгрөгийн төсөв батлагдаж 1 багц тендерийг худалдан авах ажиллагааны tender.gov.mn цахим системээр дамжуулан нээлттэй тендер зарлан харьцуулалтын аргаар Дүүрэн гэгээ ХХК-тай хүнсний материал нийлүүлэх гэрээ байгуулан гүйцэтгэлээр 85,041.0 мянган төгрөгийн хүнсний материал худалдан авсан байна.

Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжүүлэх хүрээнд Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээс ерөнхий гэрээ байгуулсан гүйцэтгэгчээс Хүүхдэд ээлтэй сургалтын орчин төсөл хөтөлбөрийн нөхөн хангалтын зардлаас 67,808.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч харин бусад хангамж бичиг хэргийн бараа материалыг шууд худалдан авалтын аргаар худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянхонгор сумын ерөнхий боловсролын Соого Сейкео сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Номгон аудит ХХК-ийн ахлах аудитор О. Мандах гүйцэтгэж, хяналтыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор сумын ерөнхий боловсролын Соого Сейкео сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитад шаардлагатай баримт материалыг Номгон Аудит ХХК-д 2024 оны 1 дүгээр сарын 19-ны өдөр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал



Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант жилийн батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны үр дүнгийн нийт зардлаар 1,657,942.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 16,579.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 12,434.6 мянган төгрөгөөр тогтоож гүйцэтгэлийн шатанд дахин тодорхойлох шаардлагагүй гэж үзэв..

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаас цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1,866,434.0 мянган төгрөгийн 75 гүйлгээ, зарлагын 218,260.6 мянган төгрөгийн 21 гүйлгээ, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой шийдвэрийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Азбаяр гүйцэтгэж, менежментийн захидлаар Шилэн дансны цахим сайтад гэрээний мэдээлэл байршуулах зөвлөмжийг байгууллагын удирдлагад хүргүүлсэн байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт



/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	1-	-	1	-	100
Нийт дүн	1	-	1	-	100.0

Эх сурвалж: Баянхонгор сумын Соого Сейкео сургуулийн 2023.03.15-ны өдрийн 39 дүгээр албан бичиг

Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг тус байгууллагаас 2023.03.15-ны өдөр 39 дүгээр албан бичгээр ирүүлсэн, зөвлөмжийг бүрэн биелүүлж ажиллажээ

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна..

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар зөрчил дутагдал илрээгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

--oOo---

